



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.01.22 № 03

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Шийдвэрийн хууль зүйн
үндэслэлийг хянуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.

1.Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 792,000 (долоон зуун ерэн хоёр) мянган төгрөг" болгож нэмэгдүүлэх шийдвэр гаргасан.

Энэ нь Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт "Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо энэ хуулийн 4.2-т заасан хүчин зүйлийг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жилд нэг удаа тогтоох...", 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан дагаж мөрдөх хугацааг тогтоосон заалттай нийцэж байгаа эсэх тухай асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



А.АРИУНЗАЯА

2025000007